



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

2025 оны 4 дугаар сарын 16

Дугаар 1502

Улаанбаатар хот

Тамга, тэмдгийн хяналтын
дугаар хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.7.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарг-ын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 14-д заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Олон-Овоот гоулд ХХК (5099005)-ийн Итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Анастасиягийн гаргасан хүсэлтэд Олон овоот гоулд ХХК нь тамга, тэмдгээ хаяж үрэгдүүлсэн тул хяналтын дугаар шинээр олгож өгнө үү.” гэсний дагуу мэдээллийн санд бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд Олон-Овоот гоулд ХХК-нд 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 001/161 тоот “Үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулах тухай” албан бичигт ТТА5150 дардас тэмдэглэгээтэй, Монгол Улсын иргэн Г.Алтан 50 хувь, Суробан ХХК 50 хувийн хувьцааг тус тус эзэмшиж байна. Гүйцэтгэх удирдлагаар Г.Алтан бүртгэлтэй байх бөгөөд өнөөдрийн байдлаар тус хуулийн этгээдэд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хоригийн бүртгэлийг 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 187/05 тоот тогтоолоор сэргээсэн бүртгэл байна.

2.Олон-Овоот гоулд ХХК-ийн Итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Анастасиягийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргаж өгсөн нотлох баримтыг хянан үзэхэд: Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, 7 давхарт байршилтай, Олон-Овоот гоулд ХХК-ийн тамга, тэмдгийн хяналтын ТТА5150 дугаартай тэмдгийг гээгдүүлсэн тухай 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, түүнд Суробан ХХК-ны гүйцэтгэх захирал, итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Анастасиягийн гарын үсэгтэй, 2025 оны дүгээр сарын 14-ний өдрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Анастасиягийн гарын үсэгтэй хүсэлт, Нийслэлийн тойргийн нотариатч Б.Батсүрэнгийн 2024 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн №0169 дугаартай Өвлөх эрхийн гэрчилгээ, Их британи, Умард ирландын нэгдсэн хаант улсад суугаа элчин сайдын яам нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн №0895 дугаартай Ж.Одмандахаас Д.Анастасияд “Г.Алтангийн Олон-Овоот гоулд ХХК-ийн хувьцаа,

1525030060

Суробан ХХК-ний хувьцаа эзэмших эрхүүдийг дээр өв хүлээн авах хүсэлт...үйлдэл хийх бүрэн эрхийг олгосон” итгэмжлэл, Өдрийн сонины 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн №191(7557) дугаарт хүчингүйд тооцсон тухай зар зэрэг нотлох баримтаар Олон-Овоот гоулд ХХК нь тамга, тэмдгийн хяналтын ТТА5150 дугаартай тэмдгийг гэсэн болох нь нотлогдож байна.

3.Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Олон-Овоот гоулд ХХК-ийг 500 нэгжээр торгож, энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 250 нэгжээр хөнгөрүүлж, торгож шийтгэл оногдуулсан тухай Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 0920383 дугаартай шийтгэлийн хуудас байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1-т “Хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт “Тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцож, хяналтын дугаарыг улсын бүртгэгч ажлын 2 өдрийн дотор дахин олгоно.” гэж заасныг тус тус баримтлан ДҮГНЭХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 5099005 регистрийн дугаартай Олон-Овоот гоулд ХХК-д олгосон тамга, тэмдгийн хяналтын ТТА5150 дугаарыг хүчингүй болгох.

2.Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Олон-Овоот гоулд ХХК-д мэдэгдэх.

3.Байгууллагын цахим сайтад байршуулах арга хэмжээ авах.

Дүгнэлтийн хувийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлэх.

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  М.МӨНХГЭРЭЛ